



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.08.06 № 1863  
танай -ны № -т

АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ  
НАМЫН ДАРГА А.БАТДОРЖ ТАНАА

Г Хандивын тайлангийн дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох “Ард түмний олонхийн засаглал нам”-ын ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6, 26.4.6-д заасны дагуу иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь хандивын тайланг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлт**

“Ард түмний олонхийн засаглал нам” 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хандивын тайланд тусгасан нийт 50.000 /тавин мянган/ төгрөгийн хандивыг “Улс төрийн намын тухай” хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



Z:\Yawsan\Bichig\2021\0805 ADD-23.Docx

90000001

01031069

**УИХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛД ӨГСӨН ХАНДИВЫН ТАЙЛАНГИЙН МЯГТ  
АРД ТУМНИЙ ОЛООНХИЙН ЗАСАГЛАЛ НАМ.**

/МЯН.ТЕГ/

	Хамрах хугацаа: 2020 оны 01 Дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон		
Д/д	Хандив өгсөн иргэний тоо	Нөхөн сонгуулийн хандивын дүн	Тайлбар
1	1	50.0	
2	Хандив өгсөн хуулийн этгээдийн тоо	Нөхөн сонгуулийн хандивын дүн	-
	Нийт	1	50.0

**Санамж: Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар эзүүлийн 26.3.6, 26.4.6-т заасан ирээн, хуулийн этгээдээс өгсөн хандивет намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамралуулахгүй болно.**